



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 9 сарын 26 өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах  
тухай

Засгийн газрын 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 27 дугаар тогтоол, “Орон сууцны санхүүжилтийн корпораци” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Төрийн албан хаагчид болон иргэдийг орон сууцаар хангах арга хэмжээний тухай Засгийн газрын 2009 оны 321 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаас гарган санхүүжүүлсэн “4000 айлын орон сууц” хөтөлбөрийн зээлийн багцыг Төрийн банкинд шилжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурьдсан бүрэлдэхүүнээр байгуулж, Ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

**Ажлын хэсгийн ахлагч:**

Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын  
газрын Санхүүгийн зах зээл, даатгалын  
хэлтсийн мэргэжилтэн

Н.Мандуул

**Гишүүд:**

Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын  
газрын Санхүүгийн зах зээл, даатгалын  
хэлтсийн мэргэжилтэн

Л.Мөнхдэмбэрэл

Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын  
газрын Санхүүгийн зах зээл, даатгалын  
хэлтсийн мэргэжилтэн

Н.Билгүүн

“Орон сууцны санхүүжилтийн корпораци”  
ХХК-ийн Татан буулгах комиссын  
нарийн бичгийн дарга

Л.Цэцгээ

Төрийн банкны Үйл ажиллагааны эрсдэлийн  
удирдлагын хэлтсийн захирал

Л.Мөнхбаяр

Төрийн банкны Бүртгэлийн бодлого,  
хяналтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн

Л.Ундрас

Төрийн банкны Хяналт, шалгалтын газрын  
Ахлах хянан шалгагч

М.Дэлгэртөгс


Төрийн банкны Зээлийн бодлогын газрын  
Ахлах мэргэжилтэн

Ч.Дашсүрэн

Хоёр. “4000 айлын орон сууц” хөтөлбөрийн зээлийн багцыг үнэт цаасны хоёрдогч зах зээлд гаргахаар тооцож, гэрээний ерөнхий нөхцлийг тохиролцон Төрийн банкинд шилжүүлэх саналаа танилцуулахыг Ажлын хэсэг /Н.Мандуул/-т даалгасугай.

Гурав. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газар /Б.Нямаа/-т даалгасугай.

САЙД



Ч.УЛААН